



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 20 өдөр

Дугаар А/111

Шивээговь сум

Сумын 1-р багт хийгдэх нийтийн биеийн тамирын талбай /Хөл бөмбөгийн талбай/ байгуулах, шинэчлэх ажлыг хүлээж авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Шивээговь сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааны 06 дугаар “Сумын 2024 оны төсөв батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй “Сумын 1-р багт хийгдэх нийтийн биеийн тамирын талбай /Хөл бөмбөгийн талбай/ байгуулах, шинэчлэх ажил”-ыг хүлээж авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга

Л.Бадамханд
(Засаг даргын орлогч)

Гишүүд:

Б.Дэлгэрдалай
(Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилгын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)
Д.Будсүрэн

(Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад)

А.Отгонтуяа
(Орон нутгийн өмчийн газрын дарга)

Л.Одонтуяа
(Архивын тасгийн дарга)

Т.Эрдэнэбаяр
(Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилгын техникийн хяналтын Улсын байцаагч)

Д.Буяндэлгэр
(Ерөнхий боловсролын сургуулийн захирал)


Д.Баттуул
(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа

Нарийн бичгийн дарга:

хариуцсан мэргэжилтэн)
Б.Бат-Ундрах
("Цагаан толгойн нуур" ХХК-ийн
ерөнхий захирал)

2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй "Сумын 1-р багт хийгдэх нийтийн биеийн тамирын талбай /Хөл бөмбөгийн талбай/ байгуулах, шинэчлэх ажил"-ыг хүлээн авч ашиглалтад оруулах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг комиссын дарга (Л.Бадамханд)-д, өмч хөрөнгийг бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн (Д.Баттуул)-д, өмч хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, үр ашгийг дээшлүүлэн, ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллахыг байгууллагын дарга (Д.Буяндэлгэр)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.СУГАРМАА